# Хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдлын судалгааны үр дүн

Улаанбаатар хот

2020.11.26

# АГУУЛГА

- Бизнест үзүүлж буй нөлөө
- Хүндрэл ба шаардлагатай дэмжлэг
- Дүгнэлт, санал

# Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

11 сарын 23-25-ны өдрүүдэд нийт **3530 ААН**, бизнес эрхлэгчдээс цахимаар судалгааг авсан.

## Салбараар




## Борлуулалтын орлогоор




## Ажиллагсдын тоогоор



# Бизнест үзүүлж буй нөлөө

## Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээ нь бизнест нөлөөлсөн байдал




## Салбараар



# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (үйл ажиллагаанд)

## Хөл хорионы үед аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж буй байдал




## Салбараар




Хувиараа бизнес эрхлэгчдийн **82%** нь бүрэн зогсолт хийсэн бол **13%** нь хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байна

# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (үйл ажиллагаанд)



# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (ажлын байранд)

## Аж ахуйн нэгжүүд өөрийн нөөцөөр ажлын байраа хадгалах боломжтой хугацаа




## Салбараар



# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (ажлын байранд)

**12 сарын 1 хүртэл**

**2020 оны 12 сарын 31 хүртэл**
(1 сараар сунгавал)

**2021 оны 3 сарын 1 хүртэл**
(3 сараар сунгавал)

(Хатуу дэглэмийн хөл хорио тогтоох хугацаа)




**152,900**
ажлын байр цөөлсөн

**432,600**
ажлын байр цөөлнө

**505,060**
ажлын байр цөөлнө

- Ажлын байрны тоог өөрчлөөгүй/өөрчлөхгүй
- Ажлын байрны тоог цөөлсөн/цөөлнө
- Ажлын байрны тоог нэмсэн/нэмнэ
- Бүрэн зогсолт хийж ажилчдаа бүгдийг халах/халсан
- Одоо хэлэхэд эрт байна
- Linear (Ажлын байрны тоог цөөлсөн/цөөлнө)

# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (ажиллагсдын цалинд орсон өөрчлөлт)







Хувиараа бизнес эрхлэгчдийн **74%** нь цалин олгохгүй байгаа бол **14%** нь цалингаа 100 хувь олгож байна.

# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (санхүү)

Аж ахуйн нэгжүүдийн бэлэн мөнгө (эргэлтийн хөрөнгийн)-ний нөөцийн хүрэлцээтэй хугацаа




Салбараар



# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (зээл)




Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн **72%** нь бизнесийн зээлтэй




Хувиараа бизнес эрхлэгчдийн **67%** нь 50 сая төгрөг хүртэл зээлтэй байна.

# Хатуу хөл хорионы бизнест үзүүлж буй нөлөө (борлуулалтын орлогод)




Хувиараа бизнес эрхлэгчдийн **72%** нь борлуулалтын орлого 91 хувиас дээш хэмжээгээр буурсан

# АГУУЛГА

- Бизнест үзүүлж буй нөлөө
- Хүндрэл ба шаардлагатай дэмжлэг
- Дүгнэлт, санал

# Хөл хориотой холбоотой бизнест үүсээд буй хүндрэл




Хувиараа бизнес эрхлэгчдийн **67%** нь зээлийн эргэн төлөлт хийж чадахгүй байгаа бол **61%** нь түрээсийн төлбөр хийхэд хүндрэлтэй гэж хариулсан.

# Хөл хорионы үед шаардлагатай дэмжлэг

| | 2020 оны 11 сарын 18-ны өдрийн Засгийн газрын 183 тоот тогтоолд тусгасан арга хэмжээний дэмжлэг болсон байдал | % |
|---|---|---|
| 1 | Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаанд өөрчлөлт оруулах | 50% |
| 2 | Хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, түгээлт, борлуулалтын үйлчилгээг хэвийн явуулахад чиглэсэн арга хэмжээ | 29% |
| 3 | Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах | 24% |
| 4 | Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг сунгах | 15% |
| 5 | Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд идэвхжүүлэх | 14% |
| 6 | Татвар төлөгчийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн авлага, бусад илүү төлөлтийг татварын өрөнд суутгах | 12% |
| 7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын барааг худалдан авах | 11% |
| 8 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллах | 11% |
| 9 | Импортын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх | 9% |




Хувиараа бизнес эрхлэгчдийн **58%** нь **Бизнесийн үйл ажиллагааг тодорхой хувиар үргэлжлүүлэх боломж олгохыг** хүсэж байна

# Хөл хорионы дараа шаардлагатай дэмжлэг




Хувиараа бизнес эрхлэгчдийн хамгийн шаардлагатай байгаа дэмжлэг нь **санхүүгийн дэмжлэг-57%** болон **хөнгөлөлттэй зээл -49 %** байна.

# АГУУЛГА

- Бизнест үзүүлж буй нөлөө
- Хүндрэл ба шаардлагатай дэмжлэг
- Дүгнэлт, санал

# Дүгнэлт, санал

Хатуу хөл хорио сунгасан тохиолдолд эдийн засгийн болон экспортын гол салбаруудын үйл ажиллагааг сэргээх, хэвийн явуулах; ААН-үүдийг ажлын байраа хадгалахад нь дэмжлэг үзүүлэх; цар тахлаас үүдэн ихээхэн хохирол амссан хувиараа бизнес эрхлэгчид болон жижиг бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн **санхүүгийн дэмжлэг үзүүлэх багц арга хэмжээг** хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

1. Үйл ажиллагаа бүрэн зогссон, ихээр хязгаарлагдсан салбарын бизнест санхүүгийн дэмжлэг үзүүлэх
2. Богино хугацааны ажилгүйдлийн эсрэг чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх
3. Жижиг дунд бизнес эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгчид, цар тахлын нөлөө хүндээр туссан салбарын ААН-үүдэд баталгаа шаардахгүй, хүүгүй болон маш бага хүүтэй зээл олгох
4. Цар тахлын нөлөөллийн улмаас борлуулалтын орлогогүй болон орлого нь маш доогуур байгаа ААН-үүдийн цалингийн зардалд татаас өгөх
5. Нөлөөлөлд өртсөн ААН-үүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах буюу чөлөөлөх
6. Нөлөөлөлд ихээр өртсөн салбарын жижиг дунд ААН-ийн тогтмол зардлыг санхүүжүүлэх, түрээсийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх
7. Нөлөөллийн улмаас бизнес нь доголдсон аж ахуйн нэгжүүдэд зээлийн үндсэн ба хүүгийн төлбөрийн татаас өгөх
8. Нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдийг санхүүгийн хөрвөх чадвараар хангах зорилгоор олгох банкны зээлийн хүүг бууруулахад дэмжлэг үзүүлэх г.м.

# Анхаарал хандуулсанд баярлалаа